



WORLD BANK GROUP

THE WORLD BANK
IBRD • IDA

IFC

International
Finance Corporation

MIGA

Multilateral Investment
Guarantee Agency

Монгол Улс:

*Хувийн хэвшлийн
судалгаа, тайлан*

ХУРААНГУЙ



2026 ОНЫ ЕСДҮГЭЭР САР

Хувийн хэвшлийн судалгаа, тайлангийн талаар

Хувийн хэвшил нь эдийн засгийн урт хугацааны өсөлтийн хөдөлгүүр бөгөөд дэлхийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хурдасгуур болдог. Хувийн хэвшил нь сайн ажиллаж буй үедээ инновац, бизнес эрхлэлтийг нэмэгдүүлж, эдийн засагт илүү чанартай, хүртээмжтэй боломжийг бий болгож, байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтад нэмэр болдог. Хөгжиж буй эдийн засгуудад хувийн хэвшил нь ажлын байрны дийлэнх орон тоог бий болгож, татварын орлого, хөрөнгө оруулалтын томоохон хэсгийг хариуцдаг.

CPSD тайлангууд нь хувийн хөрөнгө оруулалтын хязгаарлалтуудыг бодлогын арга хэмжээгээр арилган шийдвэрлэж хувийн хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Дэлхийн Банк Групп (ДБГ)-ийн байгууллагууд хамтран боловсруулсан энэхүү тайлангийн бүлэг тус бүрд зохистой бодлогыг хэрэгжүүлж, зохицуулалтын асуудлуудыг шийдвэрлэсэн тохиолдолд нэмэлт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар өсөлтийг хурдасгах боломжтой эдийн засаг дахь тодорхой салбаруудын дүн шинжилгээ агуулагддаг.

Хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн байр сууринаас боловсруулсан CPSD тайлан нь идэвхжээгүй хувийн хөрөнгө оруулалтын боломжууд болон тэдгээрийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг тодорхойлохыг эрмэлздэг (өмнөх тайлангуудтай энэ холбоосоор танилцаж болно). Эдийн засгийн дэд салбаруудыг чиглэсэн бодлогын арга хэмжээний үр дүнд хувийн хөрөнгө оруулалт татах, илүү олон, чанартай ажлын байр бий болгох, дотоод орлого бүрдүүлэх, тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг дэмжих зэрэг шалгуурт үндэслэн сонгодог. Тайлан нь бодлого боловсруулагчдад хувийн хөрөнгө оруулалтын удаашралыг арилгангаа илүү далайцтай хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд ойрын хугацаанд хэрэгжүүлж болох үр нөлөөтэй арга хэмжээнүүдийг чухалчлахад тус болоход чиглэсэн болно.

CPSD тайлан нь тухайн улсын стратеги, төрийн болон хувийн хөрөнгө оруулалтын төсөл, төсвийг дэмжих үйл ажиллагаа, зөвлөх үйлчилгээ болон бусад судалгааны ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийг удирдах зориулалттай Дэлхийн Банк Группийн боловсруулдаг үндсэн судалгааны баримт бичиг юм. Энэхүү судалгаа нь дотоод болон гадаадын хөрөнгө оруулагч, төрийн албан тушаалтан, Дэлхийн Банк Группийн ажилтан болон удирдлага, нийгэм болон бусад түншүүдийн сонирхол өдөөх, анхаарал татах зориулалттай юм.

CPSD тайлан нь Дэлхийн Банк Группийн ажлын байрны бодлогын гол хэрэгслийн нэг бөгөөд энэ нь 2025 оны Хөгжлийн хорооны "Ажлын байр: Хөгжил цэцэглэлтийн зам" баримт бичигт тусгагдсан байдаг. Уг баримт бичигт хувийн хэвшлийн хөгжлийг илүү өргөн хүрээтэй ажил эрхлэлтийн боломжид хөрвүүлэх шаардлагыг онцлон тэмдэглэсэн байдаг. CPSD тайланд тусгагдсан улс орны болон салбарын түвшний дүн шинжилгээнүүд нь ажлын байр бий болгоход чухал ач холбогдолтой хувийн хөрөнгө оруулалтад тулгарч буй тогтолцооны шинжтэй саад бэрхшээлийг тодорхойлоход тус болдог. Энэхүү тайлан нь Хөгжлийн хорооноос тодорхойлсон хүний нөөцийн чадавх, дэд бүтцэд хөрөнгө оруулах замаар ажлын байр бий болгох суурь нөхцөлийг бүрдүүлэх, бизнесийн орчныг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх, мөн аж ахуйн нэгжүүдийн илүү олон тооны чанартай ажлын байр бий болгох чадавхыг өргөжүүлэхэд хувийн хөрөнгийг өргөн хүрээнд ашиглах талаарх хувийн хэвшлийн хөгжил, ажлын байр бий болгох бодлогод нийцнэ.

Монгол Улс:

Хувийн хэвшлийн судалгаа, тайлан

ХУРААНГУЙ



2026 ОНЫ ЕСДҮГЭЭР САР



WORLD BANK GROUP

THE WORLD BANK
IBRD • IDA

IFC

International
Finance Corporation

MIGA

Multilateral Investment
Guarantee Agency

Талархал

Энэхүү CPSPD тайланг Дэлхийн Банк Группийн олон салбарын мэргэжилтнүүд хамтран боловсруулсан болно. Үндсэн багийг Алексей Волков болон Вэнтинг Вэй нар хамтран ахалж, багийн бүрэлдэхүүнд Жулиана Биэлл, Дүгэрээгийн Жигжидмаа, Хавиэр Гомэз Рэстрепо, Лэвэнт Карадаи болон Нацүко Тоба нар багтсан. Өргөтгөсөн багт Батмөнхийн Ундрал, Нисачол Мэхарат, Винсент Палмэйд болон Иссэй Такахаши нар ажилласан бөгөөд Адама Баджи, Цогтбаатарын Уянга, Энхсайханы Аззаяа, Баясгалангийн Болороо болон Төмөрийн Сүхчимэг нар багт өргөн хүрээний захиргааны дэмжлэг үзүүлсэн.

CPSPD тайлан нь Эльвира Морелла, Франческо Стробб, Жэффри Челски нарын удирдлага, хяналтын дор, мөн Паоло Мауро, Денис Медведев, Мара Ворвик, Арноуд Дупойзат болон Жэк Сидик нарын ерөнхий удирдамжийн хүрээнд хийгдсэн болно.

Тайлан боловсруулалтын өөр өөр үе шатанд Кимбэрли Дэвирст, Томас Хэйвэн, Тодор Милчевски, Зейнаб Партов, Ниэл Пэрэйра, Майкл Стэнли, Ухнаагийн Сарангоо, Зенаида Хэрнандэз Юриз болон Шобана Вэнкатарам нар хөндлөнгийн хяналт тавин ажилласан.

Болдбаатарын Дэлгэрмаа, Ибрахим Этэм Эртэн, Сумъяагийн Вандандорж, Цэвэгмидийн Түмэнцогт болон Мэри Луиз Витэлли нар мэргэжлийн дэмжлэг үзүүлж, Скотт Вэнгер болон Хилари К. Жонсон редакцын туслалцаа үзүүлсэн.

Багийн зүгээс удирдамж, санал зөвлөмж өгсөн бүх хүмүүст талархлаа илэрхийлэхийн дашрамд Тэхён Ли болон Мэттью Д. Лө Блан нарын ахалсан дотоод багуудын мэдлэг, туршлагад онцгойлон талархаж байна. Үнэтэй хувь нэмэр оруулсан Дэлхийн Банк Группийн бусад хамтран ажиллагчдад мөн талархлаа илэрхийлье. Үүнд (цагаан толгойн дарааллаар) Элчин Акжура, Руфат Алимарданов, Батбаярын Замилан, Батболдын Батмөнх, Лэжи Цао, Чадраавалын Бурмаа, Саужаня Чодаварару, Доржийн Амарбаясгалан, Николас Дэвид Элмс, Майкл Энгман, Пүүжа Гоэл, Марко Гружисич, Роумин Ислам, Мвэва Капотвэ, Эдвард Чунг Нин Күнг, Эва Климович, Шү Чү К., Рүижинг Лин, Ситарамачандра Мачиражү, Шон Манн, Элитза Милева, Жэймс Морли, Тиласони Бэнжамин Мүсүкү, Гаутам Наллавари, Дэвид Обарчанин, Стивэн Поттер Поттер, Свэн Рэннэр, Сантиаго Маррон Руиз, Хосе Луис Диаз Санчез, Алехандро Руэда Санз, Соломия Шпак, Янчин Сонг, Мариус Висмантас, Эшли Ван, Юн Ву болон Алэссио Занэлли нар багтаж байна.

Баримт бичиг, мэдээллээр хангахын зэрэгцээ олон уулзалтад оролцон дэмжсэн Дэлхийн Банк Группийн бусад ажилтнуудад талархал илэрхийлж байна.

Тайлангийн чанарыг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулан, санал бодлоо хуваалцсан төрийн байгууллагын албан хаагчид, хувийн хэвшлийн төлөөлөл, хөгжлийн түншүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд болон бусад оролцогч талуудад мөн талархал илэрхийлж байна.

Хураангуй

CPSD тайлан нь дунд хугацаанд ихээхэн хэмжээний хувийн хөрөнгө оруулалт татах боломжтой эдийн засгийн салбаруудыг тодорхойлж, тэдгээрт тулгамдаж буй хязгаарлалтуудыг төрийн бодлогоор шийдвэрлэх боломжийг үнэлдэг. CPSD тайлан нь хувийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж буй хүчин зүйлсэд хөрөнгө оруулагчдын талаас дүгнэлт хийдэг. Салбаруудыг нарийн нягт, системтэй үйл явцын дагуу сонгодог бөгөөд үүнд тоон өгөгдөл болон чанарын шинжилгээг нэгтгэн хувийн хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгж, техникийн мэргэжилтнүүд, бодлого тодорхойлогчид, хөгжлийн хамтрагчид зэрэг оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөөн уулзалт, ярилцлага багтана. Энэхүү үйл явцад талуудын санал шүүмж тусгагдсан учир салбаруудын сонголт нь үүгээр хязгаарлагдахгүй бөгөөд CPSD тайлан нь төвлөрсөн шинжилгээ болон бодит зөвлөмжүүдийг дэмжихийг зорьдог юм.

Танилцуулга

Монгол Улсын урт хугацааны өсөлт, эдийн засгийн төрөлжилт, шинэ ажлын байр бий болгоход хувийн хэвшил гол үүрэг гүйцэтгэх юм. Гэвч ААН-үүд зах зээлд нэвтрэх, үйл ажиллагаа эрхлэх, өргөжин тэлэх чадварт зохицуулалтын тодорхойгүй байдал, дэд бүтцийн дутагдал, зах зээлийн гажуудал зэрэг хүчин зүйлс нөлөөлж, хувийн хөрөнгө оруулалтыг хязгаарласаар байна. Энэхүү CPSD тайлан нь тогтвортой ноолуурын боловсруулалт, нар, салхины эрчим хүчний үйлдвэрлэл, эрчим хүчний шилжилтийн ашигт малтмал (ЭХШАМ)-ын хайгуул гэсэн гурван томоохон салбарт төвлөрөн Монголын нөөц баялгаар хөрөнгө оруулалт татах бодит тогтолцоог санал болгосон. CPSD тайлан нь эдгээр салбаруудын харьцангуй давуу талтай шинж чанарыг тодорхойлж мөн хөрөнгө оруулагчдад саад учруулж буй бодлого ба институтын түвшний хязгаарлалтуудыг тогтоож гаргасан.

CPSD тайлан нь өргөн хүрээний урт хугацааны шинэчлэлүүдээс илүүтэйгээр ойрын хугацаанд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх,

дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ажлын байрыг илүү эрчимтэй нэмэгдүүлэх нөлөө бүхий тодорхой хэдэн багц арга хэмжээг чухалчилдаг.

Тайлангийн зөвлөж буй ашигт малтмалын хайгуул болон сэргээгдэх эрчим хүчний салбарт хийгдэх шинэчлэлүүд нь Монгол Улсын аж үйлдвэрийг нийтэд нь хөгжүүлэх зорилтыг урагшлуулах ба ялангуяа ашигт малтмалын олборлолт, боловсруулалт, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг ойролцоо байрлуулж дараагийн шатны металлургийн үйлдвэрлэл мөн өндөр технологийн үйлдвэрлэлийн боломжийг бий болгох нэгтгэсэн кластер бий болгох Засгийн газрын алсын хараанд дэмжлэг болох юм. CPSPD тайлан нь эдгээр аж үйлдвэржилтийн арга замд бүрэн дүгнэлт хийхгүй хэдий ч санал болгож буй шинэчлэлүүд нь тэдгээр урт хугацааны зорилтуудыг биелүүлэх суурь нөхцөл байдлыг бий болгоход зориулагдсан болно.

Тайлангийн аргачлал нь уламжлалт уул уурхайгаас гадна нар, салхины асар их нөөцтэй, эрдэс бүтээгдэхүүний гол зах зээлд ойр, дэлхийд танигдсан ноолуурын үйлдвэрлэл зэрэг олборлолтоос бусад салбар нь хөгжих томоохон боломжтой хэдий ч өндөр дүнтэй, тогтмол урсгалтай хувийн хөрөнгө оруулалт хараахан хийгдээгүй Монгол Улсад онцгой хамааралтай юм. CPSPD тайлан нь Засгийн газарт шинэчлэлүүдийг дэс дараалалтай хэрэгжүүлэх, төрийн санаачилгыг хувийн хөрөнгө оруулалтын шийдвэртэй уялдуулахад тус болох боломжтой юм. Энэхүү тайлан нь өндөр түвшний стратеги болох жишээ нь эдийн засгийн төрөлжилт болон ногоон өсөлтийг хөрөнгө оруулагчдын зан төлөвт шууд нөлөөлдөг бодит бодлогын арга хэмжээнүүдтэй гүүр мэт холбож өгнө. CPSPD зөвлөмжүүд нь салбар бүрийн цөөн хэдэн гол сорилтод төвлөрч, эрсдэлийг бууруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, зах зээлийн тэлэх боломжийг харгалзан боловсруулагдсан болно. Ингэснээр CPSPD тайлан нь Засгийн газарт дотоод гадаадын хөрөнгө оруулагчидтай илүү үр дүнтэй харилцаа үүсгэх, түүнийг бэхжүүлэх нөхцөлийг бий болгох юм.

CPSPD тайланг хэрэгжүүлэгдэх зориулалттай үйл ажиллагааны хэрэгсэл гэж үзэх нь зохистой юм. Тайлан нь эрчим хүчний дэд бүтэц, геологийн судалгаа зэрэг төрийн хөрөнгө оруулалт, тусгай зөвшөөрөл, тариф, стандарттай холбоотой бодлогын шинэчлэл, мөн баталгаа, холимог санхүүжилт, төр, хувийн хэвшлийн түншлэл зэрэг хувийн хөрөнгийг идэвхжүүлэх хэрэгслүүдийн загвар бүтцийг чиглүүлэхэд нэмэр болох юм. Түүнчлэн тайлан нь төр хувийн хэвшлийн хоорондох харилцааг тогтвортой болгоход дэмжлэг бүхий хэрэгсэл болж, шинэчлэлүүд нь зах зээлийн бодит байдалд суурилсан мөн эдгээрийг хөрөнгө оруулагчдын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээнд нийцүүлэхэд тустай. CPSPD тайлан нь салбарууд дахь боломжуудыг ойрын хугацаанд хэрэгжүүлж болох хөрөнгө оруулагчдад ач холбогдолтой багц арга хэмжээ болгон боловсруулснаар бодит хэрэгжилт рүү шилжих, хувийн хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, мөн илүү төрөлжсөн, тогтвортой өсөлтийн загварыг цаашид ахиулахад нь Засгийн газарт тус дэм болох боломжтой.


Улсын нөхцөл байдал

Тус улс нь хөдөө аж ахуйгаас уул уурхайд тулгуурласан эдийн засаг болж өөрчлөгдсөн бөгөөд уул уурхайн салбар одоогоор эдийн засгийн өсөлт, төсвийн орлого, экспортын гол эх үүсвэр болж байна. 2015-2024 онд эдийн засгийн өсөлт дунджаар 3.8 хувьтай тэнцэж, үүний гол хөдөлгүүр нь эрдэс баялагийн бүтээгдэхүүний олборлолт байсан юм. Сүүлийн жилүүд дэх уул уурхайн салбарын тэлэлт 2024 онд Монгол дунджаас дээш орлоготой орнуудын ангилалд дэвшихэд голчлон нөлөөлсөн байна. (Зураг Т.1). Гэсэн хэдий ч уул уурхайгаас хэт хамааралтай болсноор өсөлт маш өндөр хэлбэлзэлтэй болж, түүхий эдийн үнэ, гадаад эрэлт, худалдааны тасалдлаас үүдэлтэй олон давтагдсан өсөлт уналтын мөчлөгүүд тохиолдох болсон. Сүүлийн хэдэн жил нүүрсний экспорт нэмэгдэхийн зэрэгцээ өрийн удирдлага сайжирсан нь эдийн засгийн тэлэлт, нөөц бүрдүүлэлтэд дэмжлэг

Зураг Т.1

Монгол Улсын ДНБ-ий өсөлт ихэвчлэн уул уурхай болон түүнтэй холбоотой салбаруудаас хамааралтай байна

ДНБ-ий жилийн өсөлт болон гол салбаруудын оролцоо, нэгж хувь



Эх сурвалж: Дэлхийн Банк, 2024. Үндэсний статистикийн хорооны мэдээлэл.

Жич: ДНБ = Дотоодын нийт бүтээгдэхүүн. 2023-2024 онд өвлийн гамшигт цаг агаарын үзэгдэл болох зудын улмаас хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл огцом буурсан.

болж байгаа ч эдгээр нөөцүүд нь хангалтгүй түвшинд буюу ирээдүйд цочрол эрсдэл дагуулсан хэвээр байна.

Экспортын хязгаарлагдмал, төрөлжилт багатай суурь нь уул уурхайн хамаарлаас үүдэлтэй эмзэг байдлыг даамжруулдаг. Нүүрс болон зэсээр давамгайлуулсан эрдэс бүтээгдэхүүн нь экспортын орлогын 90 орчим хувийг бүрдүүлдэгээс гадна БНХАУ-ын зах зээлд хэт төвлөрч байна. Тус улсын эдийн засгийн нарийн төвөгтэй байдлын (economic complexity) үнэлгээгээр доогуур түвшинд байгаа нь өртөг өндөр бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр хангалттай төрөлжөөгүй байгааг илтгэж байна. Худалдааг дэмжих, тээвэр логистикийг сайжруулах, ялангуяа хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүний стандартыг нийцүүлэх оролдлого нь эдийн засгийг өргөжүүлэх зорилготой ч бүтцийн саад бэрхшээлийн улмаас хязгаарлагдаж байна. Эдгээр сорилтуудыг шийдвэрлэх нь гадаад эмзэг байдлыг бууруулж, илүү тогтвортой, төрөлжсөн, хувийн хэвшил тэргүүлсэн өсөлтийг бий болгоход нэн чухал юм.


Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын дийлэнх хэсэг уул уурхайн салбарт орж, ГШХО-ын дунджаар 70 гаруй хувийг бүрдүүлж байна. Олон шалтгаанаас хамаарч байгаа ч нийт эдийн засгийн хэмжээнд өндөр цалинтай ажлын байр хангалттай байхгүй тул Засгийн газар сэргээгдэх эрчим хүч болон хөдөө аж ахуй зэрэг бусад салбаруудад ГШХО татахыг зорьж байна. 2010-2020 онд шинээр бий болсон ажлын байрны 60 гаруй хувь нь илүү өндөр цалинтай уул уурхай, барилгын салбарт бус, медианаас бага цалинтай салбаруудад бий болсон. Засгийн газар энэхүү хандлагыг харгалзан үзэж, хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засаг, экспортын төрөлжилтийг чухалчилж эхэлсэн байна. Түүхэн хугацаанд татсан ГШХО-ын хэмжээ нь нэлээд хэлбэлзэлтэй байсан ч. (Зураг Т.2) тус улс нь дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувиар авч үзвэл жишиг болон бүтцийн хувьд ижил төстэй орнуудаас харьцангуй их хэмжээний ГШХО татаж чадсан байна. Гэхдээ уг хөрөнгө оруулалт нь уул уурхайд төвлөрсөн хэвээр байна.

Монгол орон хувийн хэвшлийн олон төрлийн хөрөнгө оруулалтыг экспортод чиглэсэн салбар болон дотоодын зах зээлийг төрөлжүүлэх салбаруудад татах боломжоор дүүрэн байна. Тус улсын газрын элбэг нөөц баялаг нь уул уурхайн салбарыг дэмжиж, цаг уурын нөхцөл байдал нь сэргээгдэх эрчим хүчний салбарт томоохон боломжийг олгож, газар зүйн онцлог нь бүс нутагт болон олон улсад өндөр эрэлттэй мал аж ахуйн экспортын салбарыг дэмжиж байна. Гэвч үйл ажиллагаа нь ашигтай байх эсэх нь өртгийн үр ашигтай байдал болон цар хүрээ, хэмжээнээс хамааралтай байдаг. Дотоод эдийн засаг харьцангуй жижиг ба нийслэл Улаанбаатар хотод төвлөрсөн байдаг тул компаниудын хөрөнгө оруулалт, тэлэлтийн хийх чадамжийг хязгаарлаж байна.

Салбар дамнасан асуудлууд нь тус улсын эдийн засгийн төрөлжилтийн зорилтод саад болж, хувийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж байна. Улс төрийн тогтворгүй байдал, бодлогын байнгын өөрчлөлт нь үйл ажиллагааны орчныг урьдчилан таамаглах боломжгүй болгодог бол татвар, тусгай зөвшөөрөл, зохицуулалтын

Монголын ГШХО-ын орох урсгал харьцангуй өндөр байна

ГШХО-ын цэвэр орох урсгал, 5 жилийн дундаж, 2019-2023



Эх сурвалж: Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн мэдээллийн санд суурилсан тооцоолол.

Жич: ГШХО = Гадаадын шууд хөрөнгө оруулалт. ДНБ = Дотоодын нийт бүтээгдэхүүн. Бүтцийн хувьд ижил төстэй болон жишиг улс орнуудыг Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгаанаас (Дэлхийн Банк, 2020) нэг хүнд ногдох ДНБ, тусламжийн хэмжээ, эдийн засгийн бүтэц, хүмүүн капитал зэрэг үзүүлэлтүүдээр шүүн сонгосон. Үр дүнд нь Монгол Улсыг ижил төстэй эдийн засагтай (бүтэц) болон харьцуулж болохуйц илүү хөгжингүй (жишиг) орнуудтай харьцуулсан болно. Австрали, Канад, Чили, Малайз, Катар улс жишиг оронд тооцогдох бөгөөд бусад нь бүтцийн хувьд ижил төстэй орон болно.

шаардлагын тодорхойгүй байдал нь эрсдэлийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын цар хүрээ, хугацааг богиносгодог. Түүнчлэн зохицуулалтын жигд бус хэрэгжилт, хөрөнгө оруулагчийн эрх ашгийн хамгаалалт дутмаг зэрэг засаглал болон хууль, бодлогын хэрэгжилтийн сул талууд эдгээр эрсдэлийг даамжруулдаг бөгөөд энэ нь хөрөнгийн өртгийг нэмэгдүүлж, богино хугацааны эсвэл хувийн харилцаан дээр суурилсан үйл ажиллагааг илүү дэмждэг юм. Газар өмчлөлийн давхацсан тогтолцоогоор бэлчээрийн газар ашиглалт, захиргааны эрх, уул уурхайн лицензийг зохицуулдаг нь тодорхой бус байдлыг улам ихэсгэдэг. Хөдөлмөрийн зах зээл дэх хомсдол нь өсөлтийг мөн хязгаарлаж байна. Боловсролын үр дүн харьцангуй сайн хэдий ч хувийн хэвшилд өндөр эрэлттэй тусгай, мэргэшсэн ажиллах хүч хомс байна. Ажиллах хүчний оролцоо ойролцоогоор 63.6 хувь буюу бага түвшинд хадгалагдаж, ялангуяа эмэгтэйчүүд болон залуучуудын оролцоо сул байгаа юм. Санхүүгийн систем нь хязгаарлагдмал өрсөлдөөнтэй, тодорхой хоёрдогч санхүүжилтийн суваг хомс (венчур капитал,

хувийн хөрөнгө оруулалтын сан, урт хугацаат компанийн бонд г.м.), банкны салбараар давамгайллагдсаны улмаас жижиг компаниудад санхүүгийн үйлчилгээ хүртээмж маш хангалтгүй байна. Нийт бүртгэлтэй бизнесийн 90 гаруй хувийг жижиг дунд үйлдвэр бүрдүүлдэг боловч нийт банкны зээлийн 20 хувиас бага хэсэг нь тэдэнд ногдож байна.

Монгол Улсын харьцангуй давуу тал, олон улсын эрэлтийн чиг хандлага, мөн ажлын байр, экспорт, эдийн засгийн өсөлтийг хурдасгах боломжийг үндэслэн CPSD тайланд дүн шинжилгээ хийсэн гурван салбар буюу тогтвортой ноолуурын боловсруулалт, нар, салхины эрчим хүчний үйлдвэрлэл, ЭХШАМ-ын хайгуулыг сонгосон болно.
(Хүснэгт Т.1)

Хүснэгт Т.1

Сонгогдсон салбаруудад шинэчлэлийг хэрэгжүүлснээр хөрөнгө оруулалт болон ажлын байрны томоохон боломж нээгдэнэ

Дэд салбар	Шинэчлэл хийгдвэл хувийн хөрөнгө оруулалт татах боломж	Ойрын хугацаанд шинэчлэл хийх боломж	Хөгжлийн нөлөө	
			Ажлын байр нэмэгдүүлэх	Бусад хөгжлийн нөлөө*
Тогтвортой ноолуурын боловсруулалт	ДУНД	ӨНДӨР	ДУНД	ӨНДӨР
Нар, салхины эрчим хүч үйлдвэрлэл	ӨНДӨР	ДУНД	ДУНД	ӨНДӨР
Эрчим хүчний шилжилтийн ашигт малтмалын хайгуул	ӨНДӨР	ДУНД	БАГА	ӨНДӨР

*“Бусад хөгжлийн нөлөө” гэдэг нь тухайн салбарын ажлын байр бий болгох нөлөөнөөс гадна экспортын төрөлжилт, бүтээмжийн өсөлт, нэмүү өртөг шингээлт, төсвийн орлого, эдийн засгийн тэсвэртэй байдал, уур амьсгал ба байгаль орчны тогтвортой байдал, хүртээмж, мөн өргөн хүрээнд эдийн засагтай хэрхэн илүү сайн уялдаж буй зэрэг хөгжлийн ерөнхий зорилтуудад хувь нэмэр оруулах боломжийг хэлнэ.

Тогтвортой ноолуурын боловсруулалт

Монгол Улсын түүхий ноолуурын нийлүүлэлт өндөр, дотоодын боловсруулалт хангалтгүй, мөн экспортын боломж олон байгаа тул энэ салбарт хувийн хөрөнгө оруулалт татахад тохиромжтой нөхцөл бүрдсэн байна. Олон улсад өндөр чанартай, хариуцлагатай эх үүсвэртэй, тогтвортой ноолуурын эрэлт нэмэгдсээр уг боломжийг бий болгосон. Ноолуурын үйлдвэрлэл нь тус улсын хамгийн хурдацтай өсөж буй хөдөө аж ахуйн салбаруудын нэг бөгөөд сүүлийн арван жилд 60 хувиар өссөн байна.

Тус улс нь дэлхийн нийт түүхий ноолуурын 40 орчим хувийг нийлүүлж, БНХАУ-ын дараагаар хоёрт орж байна (Зураг Т.3). Дэлхийн ноолууран хувцасны зах зээл өндөр өсөлт үзүүлэх төлөвтэй байгаа нь чанартай, хариуцлагатай эх үүсвэртэй бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлж байна. 2023 онд 3 орчим тэрбум ам.долларын үнэлгээтэй байсан тус зах зээл 2028 онд ойролцоогоор 3.5 тэрбум ам.долларт хүрч өсөхөөр байна.

Монголын түүхий ноолуурын ердөө 20 хувийг дотоодод боловсруулдаг тул үүнийг нэмэгдүүлэх боломжууд байна. Тус салбар нь хөдөө орон нутгийн эдийн засгийн гол цөм болдог. Нийт хүн амын гуравны нэгтэй тэнцэхүйц 190,000 малчин өрхийн орлогын эх үүсвэр ноолуураас хамааралтай байдаг ба цаашлаад боловсруулалтын шатанд ойролцоогоор 7,600 иргэнийг ажлын байраар хангадаг юм.

Дараах хязгаарлалтууд нь хувийн хөрөнгө оруулалтыг удаашруулсаар байна. Үүнд: доройтож буй ноолуурын чанар, тогтвортой байдал болон чанарын баталгаажуулалтын тогтолцоо хангалттай хүлээн зөвшөөрөгдөөгүй, цахилгааны

Зураг Т.3

Монгол Улс дэлхийн түүхий ноолуурын зах зээлийн томоохон нийлүүлэгч



Эх сурвалж: Монголын ноос ноолуурын холбоо (Ноолуурын салбарын өнөөгийн нөхцөл байдал), 2023.

тасалдал, зохицуулалтын тодорхойгүй байдал. Түүнчлэн түүхий ноолуурын худалдан авалт болон самнасан ноолуурын арилжааны үнийн ил тод бус байдал, өртөг багатай санхүүжилтийн хангалт хүртээмж хүрэлцээгүй, давхацсан стандартууд, мал сүргийн гарал үүслийг тогтооход хэрэгтэй мэдээлэлд нэвтрэх эрх хязгаарлагдмал, мэргэшсэн ажиллах хүчний хомсдол зэрэг нь нэмэлт хүндрэл учруулж байна.

Хувийн хөрөнгө оруулалтыг чөлөөтэй нэмэгдүүлэхийн тулд Засгийн газрын тус салбарыг дэмжих хөтөлбөрийг ноолуурын чанарыг сайжруулахад чиглүүлэх хэрэгтэй. Мал үржүүлгийн стандарт аргачлал боловсруулах, хэрэгжиж буй зэрэглэлийн стандартад тулгуурласан үнэ тогтоох тогтолцоог нэвтрүүлэх, “Цагаан Алт” хөтөлбөрийн хүрээнд ноос, ноолуур, арьс ширийн салбарыг сэргээхэд чиглэсэн зээлийн нөхцөлийг оновчтой тохируулах, олон улсын шаардлага хангаснаар дотоодын стандартыг дүйцүүлэн хангаж буйг зөвшөөрөх, мөрдөгдөж буй стандартуудын хүрээнд гарал үүслийг мөшгөн тогтоох үйл ажиллагааг эрчимжүүлэн сайжруулах хэрэгтэй.

Ноолуурын өртгийн сүлжээний дагуу нэмүү өртөг шингээх нь үйл ажиллагааг ашигтай болгоход нэн чухал юм. Ноолуурыг угааснаар 10 хувиар, самнаснаар 13 хувиар, ээрсэнээр үнийг 33 хувиар нэмэгдүүлдэх боломжтой. Ноолуурыг цамц зэрэг бэлэн хувцас болгон үйлдвэрлэхэд хамгийн их нэмүү өртөг шингэдэг бөгөөд энэ нь түүхий ноолуурын үнээс 74 хувиар өндөр байдаг.

Санал болгож буй шинэчлэлүүд нь дараах хязгаарлалтуудыг шийдэх боломжтой бөгөөд үүгээр салбарт 150 сая ам.долларын хувийн хөрөнгө оруулалт татахад дэмжлэг үзүүлэх боломжтой. Үүнд: буурч буй ноолуурын чанар, чанарын зэрэглэлийг урамшуулсан үнэ тогтоох тогтолцоогүй, салбарын улирлын мөчлөгт тохиромжгүй зээлийн нөхцөл, тогтвортой байдлын баталгаажуулалт хангалттай хүлээн зөвшөөрөгдөөгүй гэх саад, хязгаарлалтууд орж байна. Тайланд санал болгож буй арга хэмжээнүүд нь ээрмэл, нэхмэлийн салбарт 115 сая ам.доллар болон 35 сая ам.долларын хувийн хөрөнгө оруулалтын боломжийг тус тус бий болгоход дэмжлэг үзүүлж, дотоод дахь түүхий ноолуурын боловсруулалтыг нэмэгдүүлэх боломжтой юм. 2030 он гэхэд боловсруулсан түүхий ноолуурын нийт ноолуурын үйлдвэрлэлд эзлэх хувийг 20 хувиас 70 хувь болгон нэмэгдүүлснээр 5,000 хүртэлх шинэ ажлын байр бий болгоно (66 орчим хувийн өсөлт).

Нар, салхины эрчим хүчний үйлдвэрлэл

Монгол Улсын нар, салхины эрчим хүчний нөөцөөр ойролцоогоор 700 гигаватт (ГВт) нарны, 400 ГВт салхины эрчим хүч үйлдвэрлэх боломжтой. Энэ нь одоогийн эрчим хүчний хэрэглээнээс 300 дахин давсан дүн болж байна¹.

Гэвч энэхүү асар их нар, салхины эрчим хүчний нөөцөд хангалттай хөрөнгө оруулалт хийгдээгүй байна. 2024 онд сэргээгдэх эрчим хүч нь нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн зөвхөн 10 хувийг бүрдүүлсэн бол нүүрсний цахилгаан станцууд ойролцоогоор 90 хувийг нь нийлүүлсэн байна. Монгол өсөн нэмэгдэж буй нийлүүлэлтийн зөрүүг нөхөхийн тулд цахилгааны эрчим хүчнийхээ ойролцоогоор 25 хувийг импортлож байгаа бөгөөд аж үйлдвэр, уул уурхайн салбарын өсөлт нь 2050 он гэхэд эрчим хүчний эрэлтийг бараг тав дахин нэмэгдүүлэхээр байна.

Хязгаарлагдмал, хуучирсан сүлжээний дэд бүтэц нь хувийн хөрөнгө оруулалтыг царцааж буй томоохон шалтгаан болж байна. Дамжуулах шугамын хязгаарлагдмал чадамж нь сэргээгдэх эрчим хүчийг нэгтгэх, ялангуяа их хэмжээний нөөц баялагтай өмнөд бүсээс эрэлтийн төв цэгүүдэд нэгтгэхэд хүндрэл учруулдаг. Ихэнх сүлжээ нь олон арван жилийн өмнө бага ачааллын даацтай хуучирсан дамжуулах шугам ашигладаг тул алслагдсан бүсийн хувьсах сэргээгдэх эрчим хүчийг нэгтгэн авахад тохиромжгүй байдаг. Сүлжээг өргөжүүлэх тодорхой урт хугацааны төлөвлөгөө байдаггүй нь холболтын хуваарь, үйлдвэрлэлийг хязгаарлах эрсдэлийг улам тодорхойгүй болгож байна.

Шинэ хөгжүүлэлт нь салхи болон нарны эрчим хүчний төсөл эхлүүлэх боломжийг нэмэгдүүлж байна. Хэд хэдэн томоохон дамжуулах шугамын төслүүд 2030 он гэхэд ашиглалтад орох төлөвлөгөөтэй байна. Улмаар сүлжээнд холбогдсон томоохон хэмжээний төслүүдийг эхлүүлэхэд илүү таатай нөхцөл бүрдэж байгаа юм. Түүнчлэн эрэлт хурдацтай нэмэгдэж, сэргээгдэх эрчим хүчний техник, технологийн зардал буурснаас шалтгаалан төслийн үндэслэлийг сайжруулж байна. Говийн бүс нутагт нар, салхины эрчим хүчний ихээхэн нөөц байдгаас гадна үүний ойролцоо уурхайн үйл ажиллагаа өрнөдөг нь хөрөнгө оруулалтын боломж бүрдэж байна. Нар, салхины эрчим хүч уул уурхайн салбарын эрчимтэй нэмэгдэж буй эрэлтэд зардлын хувьд өрсөлдөхүйц, тогтвортой шийдлийг санал болгох юм.

Гэсэн хэдий ч зохицуулалтын хязгаарлалт нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулсаар байна. Тодорхой бус дуудлага худалдааны хуваарь, удааширсан ханган нийлүүлэлтийн үйл явц, буцаан хэрэглэх техникийн шаардлагууд зэрэг зохицуулалтын тодорхойгүй байдал нь хөрөнгө оруулагчдад саад болсон. 2026 оны 6-р сард Монголын анхны өрсөлдөөнт сэргээгдэх эрчим хүчний дуудлага худалдааг зохион байгуулсан нь 2019 онд танилцуулсан дуудлага худалдааны механизмыг хэрэгжүүлэхэд чухал алхам болсон ч дуудлага худалдааны хөтөлбөрийг баталж, үүнтэй холбоотой эрх зүйн орчныг бэхжүүлэхэд нэмэлт ажил хийгдэх шаардлагатай

байна. Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ нь зээлийн шаардлагыг хангах чухал нөхцөлүүдийг тусгаагүй. Түүнчлэн нэг худалдан авагчтай зах зээлийн загвар нь төсөл хэрэгжүүлэгчдэд худалдаа, аж үйлдвэрлэлийн салбарын томоохон аж ахуйн нэгжүүдтэй хоёр талт гэрээ байгуулах боломжийг олгохгүй байна.

Хувийн хөрөнгө оруулалт татахын тулд тодорхой шинэчлэлүүд шаардлагатай.

Тэргүүн ээлжид хэрэгжүүлэх арга хэмжээнд дараах зүйлс багтана. Үүнд: дамжуулах сүлжээний урт хугацааны төлөвлөгөөг нийтлэх, туршилтын дуудлага худалдааг эхлүүлэх тодорхой хуваарийг нийтэлж, дуудлага худалдааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, мөн авах-эсвэл-төлөх (take-or-pay), олон улсын арбитр, гэрээний нөхцөлийн ил тод байдал зэрэг нөхцөлүүдийг багтаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний загварыг шинэчлэх, гуравдагч талд дамжуулах сүлжээнд нэвтрэх эрх олгох, эрчим хүчний бөөний худалдааны өрсөлдөөнт зах зээлд шилжиж эхлэх.

Санал болгож буй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр сэргээгдэх эрчим хүчний дотоод эх үүсвэрүүдийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, нүүрстөрөгч ихээр ялгаруулдаг эрчим хүчний импортын хамаарлыг бууруулах боломжтой. Үр дүнд нь эдгээр хөрөнгө оруулалтууд 27 жилээр загварчлагдсан хугацаанд (2028-2054) нийт 5 сая тонн буюу жилийн 190,000 тонн нүүрсхүчлийн хийн ялгарлыг сэргийлж чадах тооцоололтой байна.

Саналд тусгасан шинэчлэлүүд нь нарны фотовольтаик, салхины эрчим хүч, эрчим хүч хуримтлуурын системд 230 сая ам.долларын дунд хугацааны хөрөнгө оруулалт татахад нэмэр болж чадна. Энэ нь 900 шууд, 400 шууд бус, хэрэглээний өсөлтөөр бий болох 400 ажлын байрыг бий болгож, нийтдээ 1,700 шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм.

Эрчим хүчний шилжилтийн ашигт малтмалын (ЭХШАМ)-ын хайгуул

Тус улс нь геологийн нөөц баялаг ихтэй боловч ЭХШАМ-ын хайгуул хангалттай хийгдээгүй юм². Улсын газар нутаг дийлэнх гол ЭХШАМ буюу зэс, алтны томоохон орд, мөн газрын ховор элемент (ГХЭ), лити, графит, кобальт, никелийн хувьд таатай геологийн тогтоцтой байна. Ихэнх эрдэс баялгийн хамгийн том зах зээл болох БНХАУ-тай хил залгаа оршдог болон энэ зах зээл нь зардлын давуу талыг олгож буйн зэрэгцээ тогтвортой эрэлтийг бий болгож байна. Түүнчлэн улс орнуудын засгийн газрууд болон аж үйлдвэрийн салбарын зүгээс нийлүүлэлтийн сүлжээг төрөлжүүлэхээр зорьж байгаа нь хоёрдогч эх үүсвэрүүдэд сонирхлыг төвлөрүүлж байна. Тохиромжтой нөхцөл бүрдсэн тохиолдолд Монгол хайгуулын чиглэлээр илүү их хувийн хөрөнгө оруулалт татах боломжтой юм.

Ашигт малтмалын хайгуулыг нэмэгдүүлэх нь уул уурхайн өртгийн сүлжээний үлдсэн хэсгийг идэвхжүүлэн нээж, нүүрснээс бусад олборлолтыг өргөжүүлэх суурь болдог. Ялангуяа нүүрс дээр суурилсан уул уурхай нь ДНБ-ий 25 хувь, экспортын 90 гаруй хувь, мөн 80,000 орчим шууд ажлын байрыг бүрдүүлж байгаа хэдий ч шинэ ордууд нь илрүүлэлтийн шатнаас хөгжүүлэлт болон үйлдвэрлэлийн шат руу шилжихгүйгээр салбарын ашиг тус нь тогтвортой хөгжих, өргөжих боломжгүй. Иймд, хайгуулын ажил гол саатах цэг болж байна: анхан шатны төсөл хангалттай их хэрэгжихгүй бол шинэ уурхай болон боловсруулалтын хөрөнгө оруулалт, мөн үүнээс бий болох ажлын байрны тоог хязгаарлагдмал хэвээр байх болно.

ЭХШАМ-ын дэлхийн эрэлт урт хугацаанд өсөлттэй байх төсөөлөл нь хувийн хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлсээр байна. 2021-2024 оны хооронд лити, никель, кобальт, графитын дэлхийн нийт олборлолт огцом нэмэгдсэн.

Монгол геологийн нөөц баялаг ихтэй боловч хайгуулын идэвхжил хангалтгүй байна. Хуулиар зөвшөөрөгдсөн хайгуул хийх боломжтой нутаг дэвсгэрийн 15-аас бага хувьд нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Энэ нь хайгуул хийх боломжтой газрын дийлэнх нь тусгай зөвшөөрөлд хамрагдаагүй хэвээр байгааг харуулж байгаа бөгөөд одоо байгаа тусгай зөвшөөрлүүдийн ихээхэн хэсэг нь идэвхгүй байна.

Монгол өндөр чадвартай ЭХШАМ-ын хайгуулын компанийг татаж чадах нь зөвхөн геологи бус эдгээр компаниуд нэвтрэх, хөрөнгө босгох, үйл ажиллагаа явуулах, гарах боломжтой эсэхээс хамаарна. Дунд шатны боловсруулалт, Говийн усны нөөцийн хязгаарлагдмал байдал, тээвэр болон эрчим хүчний дэд бүтэц хангалттай хөгжөөгүй зэрэг хүчин зүйлс хайгуулын хөрөнгө оруулалтад нөлөөлж байна.

Бусад томоохон хязгаарлалтууд байсаар байна. Нээлттэй геологийн өгөгдөл нь хуучирсан, хангалтгүй нарийвчлалтай байна. Энэ нь үнийн саналд суурилсан тендерийн тогтолцоонд илүү ноцтой үр дагавартай байна. Учир нь тус тогтолцоо нь компаниудыг эрсдэл, арилжааны ашигтай байдлыг үнэлэхэд шаардагддаг хангалттай геологийн өгөгдөл нээлттэй болохоос өмнө хайгуулын эрхэд өрсөлдөөнт үнийн санал хүргүүлэхийг шаарддагтай холбоотой. Үүнээс гадна хайгуулын эрх олгогдсоны дараа компаниуд холбогдох орон нутгийн зөвшөөрлийг авахад саатал болон тодорхой бус байдалтай тулгардаг. Зөвшөөрлийг хууль ёсны дагуу авсан ч олон нийтийн эсэргүүцэл нь жагсаал цуглаан болон төсөл хойшлогдоход хүргэдэг ба энэ нь бодлогын тогтворгүй байдлын үнэлгээг бэхжүүлж байна.

Хайгуулын эрсдэлийг бууруулж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулсанаар, саналд тусгасан шинэчлэлүүд нь хайгуулын үйл ажиллагаанд нэмэлт 200-500 сая ам.долларын дунд хугацааны хувийн хөрөнгө оруулалт татахад хувь нэмэр оруулах юм³.

Хайгуулын ажил нэмэгдсэнээр, 700-1,400 ажлын байр бий болох боломжтой. Үүнд шууд болон шууд бус ажлын байр багтах бөгөөд цаашлаад орон нутгийн

үйлчилгээний эрэлт нэмэгдэж, ур чадвар хөгжүүлэлт, мэдээлэл солилцооны үр дүнд хэрэглээний өсөлтөөр бий болох ажлын байрнууд мөн багтаж байна. Томоохон илрүүлэлт нь тээвэр, эрчим хүч, логистикийн дэд бүтцийн нэмэлт хөрөнгө оруулалтыг эрчимжүүлж, бүс нутгийн хэмжээд үр өгөөжийг нэмэгдүүлж болно.

Хайгуулын салбарт хийгдэх 500 орчим сая ам.долларын хувийн хөрөнгө оруулалт нь 1-2 шинэ уурхайн илрүүлэлт болон хөгжүүлэлтийг дэмжиж болох юм. Гэхдээ энэ нь таамгийн шинжтэй тоо бөгөөд геологи болон арилжааны тодорхойгүй байдлаас шалтгаалан бодит тоог таамаглах боломжгүй байна. Хайгуул амжилттай хийгдсэн тохиолдолд илрүүлэлт нь жилдээ 2 тэрбум ам.долларын уул уурхайн нэмэлт орлого, 40,000-90,000 ажлын байр бий болгох боломжтой. Энэхүү тооцоололд уул уурхай, боловсруулалт болон холбогдох үйлчилгээний шууд болон шууд бус ажлын байр мөн хэрэглээгээр өсөлтөөр бий болох ажлын байрыг оролцуулсан болно. Эдгээр үр дагавар нь төслийн амжилттай хөгжүүлэлт болон илүү өргөн хүрээтэй нөхцөл байдлаас шалтгаалах бөгөөд уул уурхайн салбарын урт хугацааны өсөлтийн дээд хязгаараас (энэ нь нэлээд өндөр байх төлөвтэй) илүүтэй хайгуулын үйл ажиллагааны тодорхой өсөлтийн боломжит нөлөөг харуулж байна.

Зөвлөмжийн тойм

Тогтвортой ноолуурын боловсруулалт

Хүснэгт Т2.2

Ноолуур боловсруулах салбарын хувийн хөрөнгө оруулалтад тулгарч буй хүндрэлүүдийг арилгах бодлогын зөвлөмжүүд

Хүндрэлүүд	Зөвлөж буй арга хэмжээнүүд
1. Ноолуурын ширхгийн чанар болон түүний тогтвортой байдал муудаж буй нь дэлхийн дээд зэрэглэлийн зах зээлд Монгол Улсын нэр хүндийг сулруулж, хувийн хөрөнгө оруулалт ашигтай байх боломжийг бууруулж байна.	1А. Мал сүргийн тоотой уялдсан шагнал (Улсын аварга малчин зэрэг бусад)-ын оронд өндөр чанартай ноолуур гарган авсан малчдыг урамшуулах өрсөлдөөнт хөтөлбөр хэрэгжүүлэх.
	<i>Хариуцсан төрийн байгууллагууд:</i> Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)
	1В. Одоогийн мал үржүүлгийн судалгааны санаачилгуудыг ХХААХҮЯ-ны удирдлага дор чанарт төвлөрсөн улсын нэгдсэн хөтөлбөрт нэгтгэх.
	<i>Хариуцсан төрийн байгууллагууд:</i> ХХААХҮЯ
	1С. Үүлдрийн чанарыг тогтмол сайжруулах үржүүлгийн стандарт журмыг боловсруулах.
	<i>Хариуцсан төрийн байгууллагууд:</i> ХХААХҮЯ
	1D. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиар дамжуулан мал амьтныг хянан бүртгэх үйл явц болон мал сүргийн удирдлагыг бэхжүүлэх зорилгоор уг хуулийн 7.4.1 дүгээр заалт, 7.4, 7.12, 7.6 дугаар хэсгийн хүрээнд малын бүртгэл, шилжилт хөдөлгөөний хяналт, мөн хорио цээрийг системтэйгээр хэрэгжүүлэх.
	<i>Хариуцсан төрийн байгууллагууд:</i> ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ)
2. Одоогийн үнэ тогтоох систем нь өндөр чанартай ноолуурыг урамшуулахгүй байна.	2А. Чанарыг тогтсон ангиллын стандартын дагуу үнэлж, урамшуулдаг үнэ тогтоох механизмыг боловсруулан үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.
	2В. Хөдөө аж ахуйн бирж (ХААБ) өндөр чанарын ноолуур гэрээлэх шинэ гэрээг нэвтрүүлэх эсвэл эдгээрийг тусгай дуудлага худалдаагаар худалдах, чанараас хамааралтай үнийн ялгааг бий болгох албан ёсны зах зээлийн сувгуудыг хөгжүүлэх үүднээс биржээс гадуурх хэлцэл болон гэрээний үндсэн дээр хийгдэх арилжааг зөвшөөрөх.

(Хүснэгт дараагийн хуудсанд үргэлжилнэ)

Ноолуур боловсруулах салбарын хувийн хөрөнгө оруулалтад тулгарч буй хүндрэлүүдийг арилгах бодлогын зөвлөмжүүд (үргэлжлэл)

Хүндрэлүүд	Зөвлөж буй арга хэмжээнүүд
	Хэрэв ХААБ-ийг одоогоор хувьчлах боломжгүй бол түүнийг чөлөөт зах зээлийн таваарын биржийн олон улсын жишигт хүргэх дараах шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх:^а 2С. ХААБ-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн талаас доошгүй гишүүд нь хараат бус, салбарт ажиллаж байсан туршлагатай байх шаардлагыг тавих. 2D. Арилжааны журам, гишүүнчлэл, арилжаанд оролцоход тавигдах шаардлага, мэдээлэх, тайлагнах үүрэг, ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт, мөн комплаенсын зөрчилд ногдуулах хариуцлагын арга хэмжээ зэргийг хамарсан ил тод, мөрдөн дагах журмыг баталж, хэрэгжилтийг өөрийгөө хянах үйл ажиллагаа болон нийтэд тайлагнахбайдлаар хангах. 2Е. Чанар тус бүрийн үнэ ханш, дуудлага худалдааны үр дүн, арилжаалагдсан ханш, арилжааны хэмжээ зэрэг мэдээллийг агуулсан чанарын ялгаатай үнэ тогтоох аргачлалыг нийтэлснээр үнэ тогтоох процессыг нээлттэй болгох. 2F. Хэрэв ХААБ-ийн үйлчилгээний хураамжийг хэвээр үлдээх бол: i. хураамжийн хууль эрх зүйн болон хувь хэмжээг тогтоосон үндэслэлийг олон нийтэд мэдээлэх, ii. хураамжийн орлогыг хуульд заасан биржийн үндсэн үйлчилгээнд тусгайлан зориулах хэрэгтэй.
	Хариуцсан төрийн байгууллагууд: ХААБ, ХХААХҮЯ
3. Засгийн газрын дэмжлэгтэй зээл олгох хуваарь нь үйлдвэрлэл ба экспортын улирлын мөчлөгтэй уялдаагүй байна.	3. ХХААХҮЯ нь “Цагаан Алт” хөтөлбөрийн хүрээнд одоогоор 48 сар хүртэлх хугацаагаар олгогдож буй хөрөнгө оруулалтын зээлийг 7 жил хүртэлх хугацаатай болгон сунгаж, боловсруулах хүчин чадал нэмэгдэхийн хэрээр хөтөлбөрийг аажмаар дуусгавар болгох заалт нэмэх хэрэгтэй.
	Хариуцсан төрийн байгууллагууд: ХХААХҮЯ, Сангийн яам (СЯ)
4. Давхардсан тогтвортой байдлын стандартууд компаниудын комплаенсын дарамтыг нэмэгдүүлж байна.	4. Дотоодын стандарттай давхацсан олон улсын стандартын шалгуурыг биелүүлсэн тохиолдолд дотоодын стандарт хангасанд тооцох.
	Хариуцсан төрийн байгууллагууд: ХХААХҮЯ

(Хүснэгт дараагийн хуудсанд үргэлжилнэ)

Ноолуур боловсруулах салбарын хувийн хөрөнгө оруулалтад тулгарч буй хүндрэлүүдийг арилгах бодлогын зөвлөмжүүд (үргэлжлэл)

Хүндрэлүүд	Зөвлөж буй арга хэмжээнүүд
5. Засгийн газрын мэдэлд байгаа МЭЕГ, Мал эмнэлгийн нэгдсэн систем (МЭНС)-ийн мэдээлэлд хандах эрх хязгаарлагдмал байгаа нь өртгийн сүлжээг хянан бүртгэхэд хүндрэл учруулж байна.	5. МЭЕГ нь мөшгөх тогтолцоо, тогтвортой байдлын баталгаажуулалтад дэмжлэг болох МЭНС-ийн мэдээллийг тэр дунд малчны нэр, дугаар, малын вакцин тарилга эрүүл мэнд, шилжилт хөдөлгөөний бүртгэл, мал эмнэлгийн сургалт, боловсруулалтын худалдан авалтын дүн мэдээллийг тусгай үүрэг бүхий этгээдэд итгэмжлэгдсэн хандах эрхийг олгох хэрэгтэй.
	Хариуцсан төрийн байгууллагууд: МЭЕГ
6. Мэргэшсэн ажилтны дутагдал нь өртгийн сүлжээний дараагийн үе шатанд нэмүү өртөг шингээхэд саад болж байна.	6. Гадаад ажилтны хязгаарлалтыг гурван жил хүртэлх хугацаагаар цуцалж, компаниудад шаардлагатай мэргэжилтнүүдийг ажилд авах боломжийг бүрдүүлж өгөх, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд заасан гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс компаниудыг гурав хүртэлх жилээр чөлөөлж, ур чадварын шилжүүлэлтэд нөлөөлөх хэрэгтэй.
	Хариуцсан төрийн байгууллагууд: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ)

а. Таваарын биржүүд нь арилжааны үйл ажиллагаа нь төрийн шууд нөлөөллөөс тусгаарлагдсан, бие даасан засаглал, хяналт, ил тод бөгөөд хэрэгжих боломжтой арилжааны дүрэм журам, нарийн нягт тайлагнал, зах зээлд суурилсан үнэ тогтоох механизмаар дэмжигдсэн үед хамгийн үр дүнтэй ажилладаг болохыг олон улсын жишиг харуулдаг. Шинэчлэлүүд нь засаглалыг бэхжүүлж бие даасан байдлыг нэмэгдүүлэх буюу удирдах зөвлөлийн бие даасан байдлыг өргөжүүлэх, хариуцлагын тогтолцоог тодорхой болгохоос гадна илүү өргөн хүрээнд эзэмшлийн шинэчлэл буюу хувьчлал зэрэг хэлбэрээр хийгдэж болно. 2С-ээс 2F хүртэлх зөвлөмжүүд нь ХААБ-ийн зах зээл дэх чиглэл болон үйл ажиллагааны бие даасан байдлыг бэхжүүлэх анхан шатны шинэчлэлүүдийг тодорхойлсон болно.

Нар, салхины эрчим хүч үйлдвэрлэлийн салбарын хувийн хөрөнгө оруулалтад тулгарч буй хүндрэлүүдийг арилгах бодлогын зөвлөмжүүд

Хүндрэл	Зөвлөж буй арга хэмжээнүүд
Сүлжээнд холбогдсон томоохон хэмжээний нарны фотовольтаик болон салхины эрчим хүчний үйлдвэрлэл – Диспетчерийн үндэсний төв (ДҮТ) худалдан авагчаар тодорхойлогдсон	
1. Тодорхой бус сүлжээний өргөтгөлийн төлөвлөгөө нь төслүүдийн арилжааны чадварт сөргөөр нөлөөлж байна.	1. Холболтын хүчин чадлыг өргөтгөх дамжуулах сүлжээний урт хугацааны төлөвлөгөөг боловсруулж нийтлэх.
	Хариуцсан төрийн байгууллагууд: Эрчим хүчний яам (ЭХЯ), Эрчим хүчний зохицуулах хороо (ЭХЗХ), ДҮТ, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ (ЦДҮС)
2. Дуудлага худалдааны тогтвортой хуваарь нийтлэгдээгүй мөн ил тод байдал хангалтгүй байгаа нь хөрөнгө оруулагчдын урт хугацаандаа урьдчилан төлөвлөх боломжийг нь хязгаарлаж байна.	2. Тогтмол шинэчлэгдэх 24 сарын дуудлага худалдааны хуваарийг нэвтрүүлэх.
	Хариуцсан төрийн байгууллагууд: ЭХЯ, ЭХЗХ
3. Одоогийн цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ (ЦЭХХАГ)-ний загварт банкны санхүүжилтийн шаардлагыг хангах нөхцөл хангалтгүй тусгагдсан бөгөөд хэлэлцээр удааширдаг нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулж байна.	3А. Томоохон хэмжээний төслүүдэд зориулсан шинээр стандартчилагдсан, банкны санхүүжилтэд тэнцэх ЦЭХХАГ-ний загварыг боловсруулж, үнэ болон үйлдвэрлэлийн хязгаарлалтын дүрмийг нийтлэх.
	Хариуцсан төрийн байгууллагууд: ЭХЗХ, ДҮТ
	3В. ЦЭХХАГ-ний хэлэлцээр, баталгаажуулалтын гол үе шатуудыг урьдчилсан байдлаар тодорхойлж нийтлэх.
	Хариуцсан төрийн байгууллагууд: ЭХЗХ
Худалдаа, аж үйлдвэрийн худалдан авагч	
4. ЦДҮС-ний сүлжээнд гуравдагч тал нэвтрэх боломж байхгүй байгаа нь боломжит нар, салхины эрчим хүч үйлдвэрлэгчдийн одоогийн сүлжээгээр дамжуулан томоохон худалдаа, аж үйлдвэрийн хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүч шууд нийлүүлэх боломжийг хязгаарлаж байна.	4А. Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчдэд ЦДҮС-ний сүлжээг ашиглан худалдаа, аж үйлдвэрийн хэрэглэгчдэд эрчим хүч шууд нийлүүлэх боломж олгох гуравдагч талын нэвтрэх дүрмийг боловсруулан батлах хэрэгтэй (нэгээс илүү худалдан авагчтай загвар).
	Хариуцсан төрийн байгууллагууд: ЭХЯ, ЭХЗХ
	4В. Системийн ахиуц үнэ (САҮ)-ийг тооцоолох ил тод аргачлал боловсруулж нийтлэх.
	Хариуцсан төрийн байгууллагууд: ДҮТ

Эрчим хүчний шилжилтийн ашигт малтмалын хайгуулын салбарын хувийн хөрөнгө оруулалтын хүндрэлийг арилгах бодлогын зөвлөмж

Хүндрэл	Зөвлөж буй арга хэмжээнүүд
1. Орчин үеийн геологийн өгөгдлийн нээлттэй, хүртээмжтэй байдал хязгаарлагдмал байгаа нь хайгуулыг удаашруулж байна.	1А. Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) зэрэг холбогдох байгууллагуудыг геологийн өгөгдлийг Үндэсний геологийн алба (ҮГА)-нд шилжүүлж, төвлөрсөн газарзүйн шинжлэх ухааны санд нэгтгэхийг үүрэг болгох.
	Хариуцсан төрийн байгууллагууд: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (АҮЭБЯ), АМГТГ, ҮГА
	1В. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс геологи, геохими, геофизик, мөн өрөмдлөгийн өгөгдлийг стандартчилсан цахим хэлбэрээр улирал бүр ирүүлэхийг шаардаж, тодорхой хугацааны дараа нийтэд нээлттэй болгох журмыг тодорхойлох.
	Хариуцсан төрийн байгууллагууд: АҮЭБЯ, АМГТГ
2. Хайгуулын эрх олгох аргачлал нь илүү чадварлаг хайгуулын компаниудыг оролцоог хязгаарлаж байна.	2А. Тойм судалгаа болон анхан шатны хайгуулын тусгай зөвшөөрлийг нэвтрүүлэх. ^a
	Хариуцсан төрийн байгууллагууд: АҮЭБЯ, АМГТГ
	2В. Хайгуулын эрхийг тендерээр олгох тохиолдолд тодорхой урьдчилсан шалгууртай, хоёр үе шаттай тендерийн аргачлал нэвтрүүлэх.
	Хариуцсан төрийн байгууллагууд: АҮЭБЯ, АМГТГ
3. Давхацсан газар эзэмшил, байгаль орчны удирдлагын төлөвлөгөөг орон нутагт хүлээн зөвшөөрөхгүй байх, олон нийтийн эсэргүүцэл зэрэг хүчин зүйлс нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсоны дараа саатал үүсгэж байна.	3А. Хайгуулын эрхийг тендерт оруулахаас өмнө АМГТГ нь газрын эзэмшил, ашиглагдах боломжтой эсэхийг баталгаажуулахыг сумын удирдлагаас шаардах хэрэгтэй.
	Хариуцсан төрийн байгууллагууд: АҮЭБЯ, АМГТГ
	3В. Тусгай зөвшөөрөл олгогдсоны дараа, хайгуулын үйл ажиллагаа эхлэхээс өмнө сумын Засаг даргыг АМГТГ-ын загварт суурилсан тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг товч, стандартчилсан хэлбэрээр түгээхийг шаардах.
	Хариуцсан төрийн байгууллагууд: АҮЭБЯ, АМГТГ
4. Стратегийн ач холбогдол бүхий орд газарт хамаарах ордын шалгуурууд тодорхой бус байгаа анхан шатны хөрөнгө оруулагчдыг оролцоог хязгаарлаж байна.	4. Стратегийн ач холбогдол бүхий ордыг тодорхойлох бодит, ил тод шалгууруудыг тусгайлан жагсааж, стратегийн ордод тооцсоны дараа бий болох үр дагавруудыг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлтөөр тусгаж өгөх.
	Хариуцсан төрийн байгууллагууд: АҮЭБЯ

(Хүснэгт дараагийн хуудсанд үргэлжилнэ)

Эрчим хүчний шилжилтийн ашигт малтмалын хайгуулын салбарын хувийн хөрөнгө оруулалтын хүндрэлийг арилгах бодлогын зөвлөмж (үргэлжлэл)

Хүндрэл	Зөвлөж буй арга хэмжээнүүд
5. Шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн үнэлгээг тооцох аргачлалын улмаас гарах эрсдэл ашигт малтмал илрүүлсний дараа огцом нэмэгддэг нь харилцан хамааралгүй этгээдтэй хийсэн гэрээний үнийг татвар ногдуулах сууриар тооцдоггүйтэй холбоотой байна.	5. Сангийн яам харилцан хамааралгүй этгээдэд шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн гэрээний үнийг татвар ногдуулах сууриар тооцох үнэлгээний зарчмыг баримтлах хэрэгтэй.
	Хариуцсан төрийн байгууллагууд: СЯ, АҮЭБЯ

- а. 2026 онд Улсын Их Хуралд хэлэлцэгдэж буй Ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл батлагдаж, үр дүнтэй хэрэгжвэл, тусгай зөвшөөрөл олгогдоогүй талбайд хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн анхан шатны геологийн судалгааны ажил хийх шинэ боломжийг бүрдүүлж, одоогийн тендерт суурилсан тогтолцооноос өөр нэг хувилбар болж чадна. Уг төслийн эцсийн хамрах хүрээ болон үр дүнтэй байдал нь парламентын хэлэлцүүлэг, хэрэгжүүлэлтээс хамаарсан хэвээр байна.

Тайлбар

1. Дэлхийн Банк Групп, 2024. Монгол Улсын Цаг уур болон хөгжлийн тайлан.
2. НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP) нь эрчим хүчний шилжилтэд шаардлагатай ашигт малтмалд (ЕТМ) хөнгөн цагаан, кобальт, зэс, бал чулуу, литий, никель болон газрын ховор элементүүдийг (REE) хамруулан тодорхойлдог. Эдгээр ашигт малтмал нь цахилгаан тээврийн хэрэгсэл болон батарей, эрчим

хүч хадгалах систем, нарны фото цахилгаан хавтан, салхин турбин, цахилгаан эрчим хүчний сүлжээ, дамжуулах дэд бүтэц, түүнчлэн аж үйлдвэр болон тээврийн салбарын өргөн хүрээний цахилгаанжуулалтад шаардлагатай гол түүхий эд юм.

3. Тооцооллуудад ашиглагдсан аргачлал болон уул уурхайн үйлдвэрлэлийн урт хугацааны нөлөөний тооцооллыг тайлангийн хавсралтаас харна уу.

© Олон Улсын Санхүүгийн Корпораци 2026. Бүх эрх хамгаалагдсан.
2121 Пенсильваны өргөн чөлөө, N.W.
Вашингтон, D.C. 20433
Интернет: www.ifc.org

Энэхүү бүтээлийн материалыг зохиогчийн эрхээр хамгаалсан болно. Зөвшөөрөлгүйгээр энэхүү бүтээлийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хуулбарлах болон/эсхүл дамжуулах нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн хэрэг болж болзошгүй. Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) нь энэхүү бүтээлд багтсан агуулга болон энд дурдсан дүгнэлт, үнэлгээний үнэн зөв, найдвартай, бүрэн бүтэн байдалд баталгаа өгөхгүй бөгөөд аливаа орхигдуулсан зүйл, алдаа (үүнд бичиглэлийн болон техникийн алдаа хязгаарлалтгүйгээр багтана), эсхүл уг агуулгад тулгуурласнаас үүдэх аливаа үр дагаварт хариуцлага хүлээхгүй болно.


Гэрэл зургийн эх сурвалж: *Нүүр зураг*: Alamy/Image Broker.

Дотоод дизайн: Patrick Ibay, <https://www.designed-for-humans.com/>.





ТАТАЖ
АВАХЫН ТУЛД
УНШУУЛНА УУ



WORLD BANK GROUP

THE WORLD BANK
IBRD • IDA

IFC

International
Finance Corporation

MIGA

Multilateral Investment
Guarantee Agency